



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багуудын дунд зарласан төслийн хүрээнд 9, 14 дүгээр хороодод худалдан авсан нисдэг дроныг харьяаллын дагуу дүүрэг дэх Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн хөрөнгөд тус тус шилжүүлсүгэй.

2. Эд хөрөнгийг холбогдох журмын дагуу хүлээлгэн өгөхийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид хамаарах хөрөнгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу бүртгэн, зориулалтын дагуу ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга /Ө.Эрдэнэхүү/, Цагдаагийн 2 дугаар хэлтсийн дарга /О.Амарсанаа/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100073



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнахаар шийдвэрлэсүгэй.

2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Чандмань одон”-гоор шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100075


Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 08 дугаар сарын
14-ний өдрийн 35 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“Чандмань одон”-гоор шагнагдах хүмүүсийн нэрс

Д/Д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1	Жамсрангийн Туяа	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн	ХЧ62031220
2	Довчингийн Амаржаргал	Чингэлтэй дүүргийн 102 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч	ХД60100601
3	Батын Янжиндулам	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн	НБ58021404
4	Данзайчойдорын Эрдэнэцогт	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны иргэн	ЛЮ58031171
5	Дэчин-Ишийн Дуламрагчаа	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн	ХМ69040404
6	Адъяасүрэнгийн Оюунгэрэл	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны “Тэгш өлзий” Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч	АЮ63032581
7	Цэрэнбатын Түмэндэмбэрэл	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны Улсын бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ОС88040417
8	Каусылгазын Султанбек	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн хуулийн зөвлөх	ШБ58071215
9	Сосорын Нямсүрэн	Хууль зүйн “Ниса” ХХК-ий гүйцэтгэх захирал	ШБ68122902
10	Борын Болорцэцэг	“Нандин хүсэл” Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэгч	АП78032166

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 08 дугаар сарын
14-ний өдрийн 35 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах хүмүүсийн нэрс

Д/Д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1	Гончигсүрэнгийн Амгалан	Чингэлтэй дүүргийн 102 дугаар цэцэрлэгийн эмч	ИИ80091603
2	Зоригтын Одонтуяа	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн	ХМ80051205
3	Дондовын Болормаа	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн	ПЮ89121803
4	Даваанямын Энэрэлмаа	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ПД85113060
5	Баасангийн Өнөржаргал	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны Зохион байгуулагч	ЧЖ86031569
6	Алтангэрэлийн Пүрэвсүрэн	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн лаборант	ХВ79060760
7	Архангай аймаг	Чулуут сум	
8	Архангай аймаг	Чулуут сум	



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, "Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам"-ыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

"МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ЦОЛ"-ООР:

- | | |
|----------------------------|---|
| 1. Бүдрагчаагийн Даш-Ёндон | Шинжлэх ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан |
|----------------------------|---|

"МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ"-ООР:

- | | |
|-----------------------------|--|
| 1. Чимэдцэрэнгийн Ган-Өлзий | Шинжлэх ухааны Академийн Философийн хүрээлэнгийн ахмад ажилтан |
| 2. Дагвын Чулуунжав | Шинжлэх ухааны Академийн Философийн хүрээлэнгийн ахмад ажилтан |

"ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-ООР:

- | | |
|-----------------------|---|
| 1. Миширийн Батжаргал | Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн |
| 2. Дамдины Октябрь | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан |
| 3. Дондовын Оюунчимэг | "Очирт тулга трейд" ХХК-ий Зөвлөх эмч |
| 4. Цэрэнгомбын Пүрэв | Шинжлэх ухааны Академийн Философийн хүрээлэнгийн Социологи, нийгмийн сэтгэл |

1150100077

зүйн эрдэм шинжилгээний ажилтан

"ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-ООР:

1. Очирын Шагдарсүрэн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны ахмад настан
2. Сэртэвийн Эрдэнэбилэг Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны ахмад настан

"АЛТАН ГАДАС ОДОН"-ООР:

1. Гооройн Баянзул Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны өндөр настан
2. Янжмаагийн Доржсүх Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны өндөр настан
3. Батын Гунгаанямба Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны ахмад настан
4. Зинамидэрийн Уранчимгээ Урт цагааны "Шинэ эхлэл" ТББ, "Чин толгой" үсчний салбарын үсчин
5. Цэрэнгийн Рагчаа Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан

"ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ААР:

1. Совдын Адилбиш Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны ахмад настан
2. Пүрэвийн Амарбаяр Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны хэсгийн ахлагч
3. Энххишигийн Батболд "Арж роуд" ХХК-ий механик инженер
4. Гомбосүрэнгийн Батдэлгэр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн, Автобус-3 ОНӨААТҮГ-ын Харуул
5. Тамирын Дүүдэй "Арж роуд" ХХК-ий Гүйцэтгэх захирал

6. Шагдарын Дэнсмаа Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны иргэн, Батбадрах ХХК-ий Захирал
7. Занабазарын Долгор Монголын Үйлдвэрлэлийн хоршооллын төв холбооны Ахмадын хорооны дарга
8. Шагжийн Лувсан Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны ахмад настан
9. Ядамсүрэнгийн Наранцэцэг Шинжлэх ухааны Академийн Философийн хүрээлэнгийн санхүүгийн ажилтан
10. Алтангэрэлийн Отгонбат "Арж роуд" ХХК-ий Ахлах инженер
11. Гомбожавын Сүнжидмаа Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан
12. Мөнхжаргалын Энхбаяр "Урт цагаан Хөм" ХХК-ий уран дархан

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 07 дугаар тогтоолын 4.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч В.Хүрэлбаатарын төрсөн эх нь хүнд өвчний улмаас байнгын эмчилгээ, сувилгаа шаардлагатай байгаа тул 1000000 (нэг сая) төгрөгийн Нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1156100079